

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 271¹ дүгээр зүйлийн 271^{1.1.1}, 271^{1.1.17} дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн хуралдааны ... дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны “Заавар батлах тухай” А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-ын “Хоёр. Гаалийн мэдүүлэг шалгах” зүйлд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

1.1. “2.11. Бичиг баримтын шалгалт дууссанаар, эсхүл гаалийн мэдүүлгийг CAIS-ийн Гаалийн бүрдүүлэлтийн програмаас шалгаж, хэлцлийн үнийг баталгаажуулсан тохиолдолд гаалийн болон бусад татварын нэхэмжлэл програмаас автоматаар үүснэ.” гэж өөрчлөн найруулах;

1.2. “2.15¹. CAIS-ийн Гаалийн бүрдүүлэлтийн програмаас шалгаж, хэлцлийн үнийг баталгаажуулсан гаалийн мэдүүлэгт хяналт шалгалтын явцад өөрчлөлт орох бол хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч өөрчлөлт оруулах хүснэгтүүдийн талаар айлбарыг алдааны талбарт бичиж, тэдгээрийг залруулахаар сүлжээгээр мэдүүлэгч рүү буцаана.” гэж нэмэх.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Энхтайван)-д даалгасугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ